



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БӨМБӨГӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 3/05

Задгай

Хог хаягдлын үйлчилгээний төлбөр,  
хураамжийн хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн "д" хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус 3 дугаар хуралдаанаас ТОГТООХ НЬ:


1.Бөмбөгөр сумын нутаг дагаж мөрдөх хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамжийн хэмжээг тогтоохыг хавсралтаар баталсугай.

2.Сумын нутаг дэвсгэрт дагаж мөрдөх хог хаягдлын төлбөрийг батлагдсан тарифын дагуу аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлдвэр үйлчилгээний газрууд, айл өрхүүдэд дагаж мөрдүүлэн, биелэлтийг хангаж, ажиллахыг сумын Засаг дарга /М.Мөнхэрдэнэ/-д үүрэг болгосугай.

3.Захиргааны Ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.5 дахь заалтын дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх ажлыг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Б.Мэндбаяр/-т үүрэг даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын "Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамжийн хэмжээг тогтоох тухай" 2019 оны 06 дугаар сарын 19-ны 6/03 дугаар тогтоол, 2020 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 2/06 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г.МАГНАЙБАЯР

1100003

Бөмбөгөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал  
2021оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн  
3/05 дугаар тогтоолын хавсралт

**Хог хаягдлын үйлчилгээний төлбөр хураамжийн хувь хэмжээ**

№	Үйлчилгээний төрлүүд	Хэмжих нэгж,	Төлбөр хураамж /тегрөгөөр/
1	2	3	4
1	Айл өрх	Хураамж /сараар/	3000
2	Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж	Хураамж /сараар/	200,000
3	Үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж	Хураамж /сараар/	15000
4	Шатахуун түгээх станц	Хураамж /сараар/	20,000
5	Бичил уурхай эрхлэгч нөхөрлөлүүд	Хураамж /сараар/	100,000
6	Төсөвт байгууллагууд	Хураамж /сараар/	15000

.....оо.....